

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ  
НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН**

**АУДИТЫН КОД: ЗАА-2026/02-12/СТА-НА-НТГ**

**Улиастай хот  
2026 он**

ᠵᠠᠪᠬᠠᠨ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ  
ᠵᠠᠪᠬᠠᠨ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

**АГУУЛГА**

**БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРӨХ ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО 46.2 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭН Ч 16 СУМАНД ОРЛОГО ТАСАРСАН БАЙНА.**

1.1 Сангийн яамнаас орон нутгийн орлогыг 943.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгийг 11,636.9 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,875.4 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ. 5

1.2 Орон нутгийн орлого нийт дүнгээр 4.1 хувиар давж биелсэн ч 16 суманд татварын орлого тасарсан байна. 6

**БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРДЛЫГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН СУУРЬ ЗАРЛАГААС 32.1 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛЖЭЭ.** 9

2.1 Орон нутгийн төсвийн урсгал зардлыг 10.1 хувиар нэмэгдүүлэн баталсан нь үндэслэлтэй байна. 9

2.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай байна. Монгол Улсын эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан Сангийн яамнаас зарцуулалтын эрхийг хязгаарласан нь нэгдсэн төсвийн гүйцэтгэл буурахад гол нөлөө үзүүлсэн байна. 10

2.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 22 хөтөлбөрөөс 15 хөтөлбөр 90-100 хувь, 7 хөтөлбөр 58-89.5 хувийн хэрэгжилттэй байна. 15

**БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ИХ ЗАСВАР, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛААС 2025 ОНД 5,662.4 САЯ ТӨГРӨГИЙН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХАСАЖ, ТОДОТГОН БАТАЛЖЭЭ.**

3.1 Завхан аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө нь бодлогын баримт бичгүүдтэй уялдсан, хэрэгжилтийн явц тогтвортой, зарим салбарт тодорхой ахиц үр дүн гарсан бөгөөд нийт дүнгээрээ 90.1 хувийн биелэлттэй байна. 18

**БҮЛЭГ 4. ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСВИЙН БОДЛОГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА Ч ШАТ, ШАТНЫ ТӨСӨВ ЗАХИРАГЧИД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,473.1 сая төгрөгөөр зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. 24

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 онд орон тоог 10.6 хувиар бууруулан тодотгосон боловч гүйцэтгэлээр 9.8 хувиар буурсан байна. 27

4.3 Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 3,990.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. 27

**БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.** 28

5.1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна. 28

ДҮГНЭЛТ 30

ЗӨВЛӨМЖ 31

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ 32



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/114

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ш.Мянганбаяр, аймгийн Засаг дарга Г.Өнөрбаяр нарт хүргүүлэхийг аудитор (Т.Баасанжаргал)-д даалгасугай.

3. Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Өнөрбаярт зөвлөсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.



Д.БАТ-УНДРАА

8126010027

АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**Аудит хийх  
үндэслэл, бүрэн  
эрх**

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2026 оны А/33 дугаар тушаал, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

**Аудитын зорилт**

Аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг бодитой тооцож төлөвлөн, бүрэн төвлөрүүлсэн эсэх;
2. Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан, ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх;
3. Аймгийн төсвийг төсвийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан эсэх;
4. Төрөөс хэрэгжүүлж буй төсвийн бодлогыг орон нутаг хэрэгжүүсэн эсэх;
5. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдсан эсэх;

**Аудитын  
хамарсан хүрээ**

Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын газрын аудитад хамрагдах татварын төлөвлөгөө, тайлан, Сангийн яамнаас Завхан аймгийн 2025 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

**Аудитын арга зүй,  
шалгуур үзүүлэлт**

Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, MNS 6817-4:2020 “Төрийн аудит. Санхүүгийн аудит”, 6817-6 :2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Аудитын арга зүй,  
шалгуур үзүүлэлт

- Тусгай сангийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл
- Завхан аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Холбогдох бусад хууль, журам эрх зүйн акт

Аудитын багийн  
бүрэлдэхүүн,  
хугацаа

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитор Т.Баасанжаргал, Л.Гансүлд нар 2026 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн, 04 дүгээр сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС  
АИТХ  
ИТХ  
ТЕЗ  
ЗДТГ  
ОНХС  
СЯ  
ХХС  
СТСХ  
ХХОАТ  
ААНОАТ  
ҮХЭХ  
ТХААГ  
НДШ  
ХХААЯ  
ОНӨГ

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт  
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  
Төсвийн ерөнхийлөн захирагч  
Засаг даргын Тамгын газар  
Орон нутгийн хөгжлийн сан  
Сангийн яам  
Хоршоог хөгжүүлэх сан  
Санхүү, төрийн сангийн хэлтэс  
Хувь хүний орлогын албан татвар  
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар  
Үл хөдлөх эд хөрөнгө  
Төрийн худалдан авах ажиллагааны газар  
Нийгмийн даатгалын шимтгэл  
Хүнс хөдөө аж ахуйн яам Орон нутгийн өмчийн газар  
Орон нутгийн өмчийн газар

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт орж, 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэгдсэн, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Завхан аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 47,537.5 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 17,294.8 сая төгрөгөөр анх баталж, тодотгосон төсвийн тухай хуулиар санхүүгийн дэмжлэгийг 11,636.9 сая төгрөгөөр бууруулж, 35,900.6 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,875.4 сая төгрөгөөр бууруулж, 12,419.4 сая төгрөгөөр баталсан байна.

Завхан аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 22 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 28,741.8 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,747.9 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 47,537.5 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 17,294.8 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 11,832.9 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 177.5 сая төгрөгөөр, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 107,332.4 сая төгрөгөөр, 2025 онд аймгийн төсвөөс зарцуулах нийт зарлагыг 107,332.4 сая төгрөгөөр анх баталжээ.

**БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРӨХ ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО 46.2 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭН Ч 16 СУМАНД ОРЛОГО ТАСАРСАН БАЙНА.**

**1.1 Сангийн яамнаас орон нутгийн орлогыг 943.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгийг 11,636.9 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 4,875.4 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Завхан аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 35,900.6 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 12,310.4 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

**Хүснэгт 1. Аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг** (сая.төгрөгөөр)

ОНХНС-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг			Улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг		Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн
ГТНАТ-н 30%	АМНАТ-н 10%	ЖГҮ	АМХТЗ-н 100%	АМАТЗ-н 50%	
362.0	10,893.4	846.6	85.6	231.9	12,419.4
<b>362.0</b>	<b>10,893.4</b>	<b>846.6</b>	<b>85.6</b>	<b>231.9</b>	<b>12,419.4</b>

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс татварын орлогыг 17,703.2 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,002.3 сая төгрөгөөр, нийт 18,705.5 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн яамнаас татварын орлогыг 27,327.4 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,543.8 сая төгрөгөөр, нийт 28,871.2 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

Монгол Улсын 2025 оны тодотгосон төсвийн тухай хуулиар татварын болон татварын бус орлогыг 943.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 29,814.4 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 11,636.9 сая төгрөгөөр бууруулан, 35,900.6 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн суурь зарлагыг 10,693.8 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Хүснэгт 2. ОНТ-ийн суурь орлого, зарлага

(сая.төгрөгөөр)

Тайлант он	Суурь орлого	Суурь зарлага	Тэнцэл	Орон нутгийн төсөвт төсөвт үлдэх	Улсын төсөвт төвлөрүүлэх	Санхүүгийн дэмжлэг
2025 оны анх батлагдсан	28,871.3	76,408.8	47,537.5	0	0	47,537.5
2025 оны тодотгосон	29,814.4	65,715.0	35,900.6	0	0	35,900.6
<b>Зөрүү</b>	<b>943.1</b>	<b>10,693.8</b>	<b>-11,636.9</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>-11,636.9</b>

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 47 дүгээр тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 32,641.8 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,755.9 сая төгрөг, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 35,900.6 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 12,419.4 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 13,939.0 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 177.5 сая төгрөгөөр, нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 96,834.2 сая төгрөгөөр баталжээ. Сумдын төсөвт байгууллагууд урьд оны үлдэгдлээс аймаг 10,801.3 сая төгрөгөөр санхүүжихээр төлөвлөсөн байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг 177.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 203.9 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

### Хүснэгт 3. Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая.төгрөгөөр)

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
Түдэвтэй сумын Ойн анги	3.5	3.0	-0.5	85.7%
Тосонцэнгэл сумын Ойн анги	31.4	34.0	2.6	108.3%
Аймгийн Засаг даргын Тамгын газар	27.6	22.7	-4.9	82.2%
Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв	115.0	144.2	29.2	125.4%
<b>Дүн</b>	<b>177.5</b>	<b>203.9</b>	<b>26.4</b>	<b>114.9%</b>

### 1.2 Орон нутгийн орлого нийт дүнгээр 4.1 хувиар давж биелсэн ч 16 суманд татварын орлого тасарсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлогыг өмнөх оноос 9,340.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод 2025 онд 1,310.0 сая төгрөг олгохоор төлөвлөж, татварын суурь орлогоос хасаж хянасан байна. Аймгийн ИТХ-ын 2025 оны 47 дугаар тогтоолоор 2025 оны татварын орлогын төлөвлөгөөг Сангийн яамны тодотгосон дүнгээс газрын дуудлага худалдааны орлогыг 220.0 сая төгрөгөөр, Татварын хүү, торгууль, алдангийн орлогыг 405.0 сая төгрөгөөр бууруулж, цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг 2,895.6 сая төгрөгөөр, шууд бус орлогыг 732.5 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 50.0 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 65.0 сая төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийг 113.3 сая төгрөгөөр, байгалийн ургалын нөөц ашигласны төлбөрийг 12.0 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 101.5 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 18.0 сая төгрөгөөр, Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг 50 сая төгрөгөөр, хүү торгуулийн орлогыг 504.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, малын тоо толгойн албан татварыг 775.1 сая төгрөгөөр тогтоож, нийт 4,564.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Татварын орлогын 2025 оны мэдээг үндэслэн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад тайлант онд аймгийн төсөвт төвлөрөх татварын орлого 1,918.9 сая төгрөгөөр буюу 46.2 хувиар давж биелсэн, сумдын татварын орлого 448.9 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар тасарсан үзүүлэлттэй байна. Үүнд:

### Хүснэгт 4. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Татварын орлогын төрөл	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	АИТХ-аар тодотгосон	Нийт төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/
		/СЯ анх баталсан/	/СЯ тодотгосон/				
ХХОАТ	Малын тоо толгойн албан татвар	-	-	755.1	585.7	965.1	164.8
	Галт зэвсгийн албан татвар	56.00	56.00	56.0	56.0	72.8	130.1
	Хөрөнгийн орлого /хүүгийн орлого/	3,130.00	3,130.00	3,130.0	3,130.0	2,233.9	71.4
	Хөрөнгө борлуулсны орлого/ ҮХЭХ, Газрын эрх борлуулсан /	235.00	235.00	235.0	235.0	436.1	185.6
	Үйл ажиллагааны орлогын албан татвар	600.00	600.00	620.0	620.0	489.5	79.0
	Шууд бус орлого /СХХОАСАТ/	160.00	160.00	872.5	856.2	1,386.3	161.9
	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	19,500.00	19,080.00	21,975.6	22,114.7	20,854.6	94.3
	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,223.00	1,223.00	1,223.0	1,223.0	1,042.8	85.3
	<b>Дүн</b>	<b>24,904.00</b>	<b>24,484.00</b>	<b>28,867.2</b>	<b>28,820.6</b>	<b>27,481.1</b>	<b>95.4</b>
	ХХОАТ-ын буцаан олголт	(1,310.00)	(1,310.00)	(1,310.0)	(1,310.0)	(1,512.7)	-
Бусад татвар	Улсын тэмдэгтийн хураамж /ТТХ-23.4.9 бусад/	75.00	75.00	75.0	75.0	132.1	176.1
	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	40.00	40.00	40.0	40.0	12.2	30.4
	Ойн нөөц ашигласны төлбөр	383.30	350.00	463.3	463.3	651.3	140.6
	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	201.50	120.00	221.5	221.5	459.7	207.5
	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	6.50	4.50	16.5	16.5	5.4	32.5
	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12.00	12.00	27.2	27.2	23.0	84.7
	Газрын дуудлага худалдаа	110.00	220.00				
	Газрын төлбөр	980.00	980.00	1,030.0	1,030.0	1,065.8	103.5
	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	110.00	110.00	128.0	128.0	111.6	87.2
	<b>Дүн</b>	<b>608.30</b>	<b>601.50</b>	<b>691.5</b>	<b>691.5</b>	<b>948.4</b>	
Татварын бус орлого	Хүү торгуулийн орлого				-	9.8	-
	Нэр заагдаагүй орлого	668.00	668.00	668.0	668.0	1,088.9	163.0
	<b>Дүн</b>	<b>668.00</b>	<b>668.00</b>	<b>668.0</b>	<b>668.0</b>	<b>1,098.7</b>	<b>164.5</b>
<b>Сумын төсвийн орлогын дүн</b>		<b>26,180.30</b>	<b>25,753.50</b>	<b>30,226.7</b>	<b>30,180.1</b>	<b>29,528.2</b>	
Аймгийн төсвийн орлого	ААНОАТатвар /40%/	700.00	2,100.00	2,100.0	2,100.0	2,749.7	130.9
	АТБЭЯХ-ийн албан татвар	589.00	589.00	589.0	589.0	588.0	99.8
	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	130.00	100.00	130.0	130.0	232.4	178.8
	Улсын тэмдэгтийн хураамж /ТТХ-23.4.9 бусад/	245.00	245.00	245.0	245.0	1,052.4	429.6
	Татварын хүү,торгууль, алдангийн орлого	587.90	587.90	151.1	151.1	165.3	109.4
	Татварын бус хүү, торгууль	432.00	432.00	936.8	936.8	979.6	104.6
	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого					255.3	
	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар					20.3	
	Газрын төлбөр					20.1	
	Зам ашигласны төлбөр					7.4	
<b>Аймгийн төсвийн орлогын дүн</b>		<b>2,683.90</b>	<b>4,053.90</b>	<b>4,151.9</b>	<b>4,151.9</b>	<b>6,070.8</b>	<b>146.2</b>
<b>Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>28,871.30</b>	<b>29,814.40</b>	<b>34,378.6</b>	<b>34,332.0</b>	<b>35,599.0</b>	<b>104.1</b>

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг 1,310.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,512.7 сая төгрөг олгож, тодотгол хийгээгүйгээр 202.7 сая төгрөг илүү зарцуулсан байна.

Төрийн аудитын газраас 2025 онд 6 нэр төрлийн орлогыг 1,002.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр санал оруулсан боловч Сангийн яамнаас 2025 оны орон нутгийн орлогыг өмнөх оноос 9.340.1 сая төгрөгөөр буюу 32.4 хувиар нэмэгдүүлсэн гэх шалтгаанаар нэмж батлаагүй байна.

Орон нутгийн татварын орлого 2025 онд 37,112.0 сая төгрөг (*татварын буцаан олголт 1,512.7 сая төгрөгийг хассан*) төвлөрч, нийт дүнгээр 4.1 хувиар давж биелсэн ч 16 суманд 0.5-19.6 хувиар тасарсан үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 5. Сумдын татварын орлогын гүйцэтгэл

(сая.төгрөгөөр)

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Алдархаан	625.6	687	61.3	109.8
2	Асгат	339.4	354	14.6	104.3
3	Баянтэс	578	516.1	-61.9	89.3
4	Баянхайрхан	488.8	480.8	-8	98.4
5	Дөрвөлжин	2,312.20	2,143.90	-168.3	92.7
6	Завханмандал	848.7	835.3	-13.4	98.4
7	Идэр	624	585.8	-38.3	93.9
8	Их-Уул	1,168.70	1,343.40	174.7	114.9
9	Нөмрөг	473.7	584.6	110.9	123.4
10	Отгон	526.3	591.6	65.3	112.4
11	Сантмаргац	477.7	432.6	-45.1	90.6
12	Сонгино	725.6	699.1	-26.5	96.3
13	Тосонцэнгэл	4,121.60	3,637.60	-484	88.3
14	Түдэвтэй	549.7	536	-13.7	97.5
15	Тэлмэн	654.3	700.5	46.2	107.1
16	Тэс	1,400.50	1,302.30	-98.1	93
17	Улиастай	12,408.10	12,584.70	176.7	101.4
18	Ургамал	468.5	537.7	69.1	114.8
19	Цагаанхайрхан	480.8	428.1	-52.7	89
20	Цагаанчулуут	436.7	351.1	-85.6	80.4
21	Цэцэн-Уул	394.4	391.3	-3	99.2
22	Шилүүстэй	513.2	475.5	-37.8	92.6
23	Эрдэнэхайрхан	426.8	397.7	-29.2	93.2
24	Яруу	446.9	444.6	-2.3	99.5
<b>Дүн</b>		<b>31,490.10</b>	<b>31,041.20</b>	<b>-449</b>	<b>98.6</b>

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Аудитын илрүүлэлт:**

Орон нутгийн татварын орлого 16 суманд 0.5-19.6 хувиар тасарсан, татварын орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлээгүй зөрчил илэрсэн тул сумдын Засаг дарга нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

**БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГЫГ САНГИЙН ЯАМНЫ ТОДОТГОСОН СУУРЬ ЗАРЛАГААС 32.1 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭН ТӨЛӨВЛӨЖЭЭ.**

**2.1 Орон нутгийн төсвийн урсгал зардлыг 10.1 хувиар нэмэгдүүлэн баталсан нь үндэслэлтэй байна.**

Орон нутгийн төсвийн 2025 оны нийт зарлагыг Сангийн яамны тодотгосон хязгаараас 31,119.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 онд урсгал зардлыг өмнөх оноос 5,677.4 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 505.0 сая төгрөгөөр буюу 15.1 хувиар нэмэгдүүлж, хөрөнгийн зардлыг 2,484.0 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар бууруулж, нийт 96,834.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

**Хүснэгт 6. Аймгийн суурь зарлагын төлөвлөлт** (сая.төгрөгөөр)

№	Зардлын төрөл	Сангийн яам /год/	АИТХ /год/	Зөрүү
1	Аймгийн ИТХ	946.8	1,994.7	1,047.9
2	Аймгийн ЗДТГ	6,315.5	5,978.8	(336.7)
3	Ойн анги	369.3	430.7	61.4
4	Байгаль орчны газар	2,318.9	2,030.8	(288.1)
5	Аймгийн халамжийн сан	314.3	211.7	(102.6)
6	Санхүүгийн хяналт аудитын алба	399.0	399.3	0.3
7	Орон нутгийн өмчийн газар	297.5	364.7	67.2
8	Хүүхдийн цэцэрлэг /тогтмол зардал/	2,477.5	2,397.0	(80.5)
9	Ерөнхий боловсролын сургууль /тогтмол зардал/	9,028.0	9,076.6	48.6
10	Эрүүл мэндийн салбар /тогтмол зардал/	4,011.2	3,210.6	(800.6)
11	Соёлын салбарын тогтмол зардал	2,182.9	2,031.9	(151.0)
12	Мэргэжлийн боловсролын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	810.6	867.7	57.1
13	Биеийн тамир спортын газар	986.9	1,198.9	211.9
14	Ахмад настны хөгжил хамгаалал	89.3	188.0	98.7
15	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг			
16	Мал эмнэлгийн үйлчилгээ, эм бэлдмэл	443.8	443.8	(0.0)
17	Засаг дарга	-	3,470.2	3,470.2
18	Хотын нийтийн тээврийн хөнгөлөлт	22.9	30.0	7.1
19	Сумдын ИТХ	5,196.9	4,008.4	(1,188.5)
20	Сумдын ЗДТГ	24,408.7	20,398.5	(4,010.2)
21	Хот тохижилт үйлчилгээний албан	1,238.7	1,791.5	552.9
22	Худалдан авах ажиллагааны алба	305.6	337.2	31.6
<b>Дүн</b>		<b>62,164.2</b>	<b>60,860.8</b>	<b>(1,303.5)</b>
1	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	5,657.9	5,657.9	-
2	Их засварын зардал	2,761.5	2,117.0	(644.5)
3	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардал	-	7,008.6	7,008.6
4	Авто замын сан	789.2	1,218.0	428.8
<b>ДҮН</b>		<b>9,208.7</b>	<b>16,001.5</b>	<b>6,792.8</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>71,372.9</b>	<b>76,862.3</b>	<b>5,489.39</b>


**Хүснэгт 7. Сумдын суурь зарлагын төлөвлөлт** (сая.төгрөгөөр)

д/д	Зардлын төрөл	АИТХ /год/	СИТХ	Зөрүү
1	Сумдын ИТХ	4,008.4	4,606.1	597.7
2	Сумдын ЗДТГ	20,398.5	24,325.1	3,926.6
3	Улиастай сумын ХТҮА	1,791.5	1,791.5	0.0
4	ОНХС	7,247.3	12,073.7	4,826.4
5	Хоршоо хөгжүүлэх сан	-	3,337.8	3,337.8
<b>Дүн</b>		<b>33,445.7</b>	<b>46,134.2</b>	<b>12,688.5</b>

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 90,265.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс 12,419.4 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 177.5 сая төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 13,939.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.


**График 1. Зардлын гүйцэтгэл (сая төгрөгөөр)**



Төсвийн нийт зарлагыг өмнөх онтой харьцуулахад 4 хувиар өссөн байна. Энэ нь 2025 онд цалин болон ТЕЗ-ийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

**График 2. Төлөвлөгөө ба гүйцэтгэл (сая төгрөгөөр)**

Тайлант онд цалин нэмэгдсэн, гэрэл, цахилгаан болон халаалтын зардлын үнэ тариф өссөнтэй холбоотой урсгал зардал 10.1 хувиар нэмэгдсэн байна.



Тайлант онд Улсын төсөвт байгууллагуудад олгох байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилтээс 900.0 сая төгрөгийг “Могойн гол” ХК руу

аймгаас шууд шилжүүлсэн нь санхүүгийн тайлан нэгтгэхэд хүндрэл үүсгэж байна. Мөн Баянтэс, Цагаанхайрхан сумдад санхүүгийн дэмжлэгийг 102.0 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Цаашид тогтмол зардлын санхүүжилтийг тухайн төсөвт байгууллагаар дамжуулан зарцуулж, санхүүгийн дэмжлэгийг батлагдсан санхүүжилтээс илүү олгохгүй байх шаардлагатай байна.

**2.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай байна. Монгол Улсын эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан Сангийн яамнаас зарцуулалтын эрхийг хязгаарласан нь нэгдсэн төсвийн гүйцэтгэл буурахад гол нөлөө үзүүлсэн байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 онд 22 хөтөлбөр арга хэмжээг 96,834.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 83,602.3 сая төгрөг буюу 86.3 хувьтай байна. Нийт зардлын гүйцэтгэлийн 67.5 хувийг урсгал зардал, 30.2 хувийг хөрөнгийн зардал, 2.3 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал эзэлж байна.

**Хүснэгт 8. Нийт зарлагын гүйцэтгэл**

(сая.төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт+ Хэтрэлт-	Дүнд эзлэх хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛ	96,834.3	83,602.3	13,232.0	86.3%
2	УРСГАЛ ЗАРДАЛ	61,653.1	56,453.7	5,199.4	91.6%

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

3	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>60,505.7</b>	<b>55,592.5</b>	<b>4,913.2</b>	<b>91.9%</b>
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,426.4	24,361.8	1,064.6	95.8%
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,173.7	3,050.9	122.8	96.1%
6	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,153.3	17,590.2	1,563.1	91.8%
7	Хангамж, бараа материалын зардал	1,149.7	941.9	207.8	81.9%
8	Нормативд зардал	192.2	158.5	33.7	82.5%
9	Эд хогшил, урсгал засварын зардал	1,218.7	991.4	227.3	81.4%
10	Томилолт, зочны зардал	459.9	422.1	37.8	91.8%
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,800.0	4,363.6	436.4	90.9%
12	Бараа үйлчилгээний бусад зардал	4,928.7	3,712.2	1,216.5	75.3%
13	<b>ТАТААС</b>	<b>30.0</b>	<b>30.0</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
14	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	30.0	30.0	-	100.0%
15	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,117.4</b>	<b>831.2</b>	<b>286.2</b>	<b>74.4%</b>
16	Бусад урсгал шилжүүлэг	1,117.4	831.2	286.2	74.4%
17	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>31,843.4</b>	<b>25,206.8</b>	<b>6,636.6</b>	<b>79.2%</b>
18	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ</b>	<b>3,337.8</b>	<b>1,941.8</b>	<b>1,396.0</b>	<b>58.2%</b>

Тайлант онд батлагдсан төсвийг 13.232.0 сая төгрөгөөр буюу 13.7 хувиар хэмнэжээ. Үүнд: Урсгал зардлыг 5.199.4 сая төгрөг буюу 39.3 хувиар, хөрөнгийн зардлыг 6,636.6 сая төгрөг буюу 50.2 хувиар, эргэж төлөгдөх зээлийн зардлыг 1,396.0 сая төгрөг 10.5 хувиар тус тус хэмнэсэн байна.

Урсгал зардлыг 5,199.4 сая төгрөгөөр хэмнэсэнд цалин, НДШ-ийн зардлыг 1,187.4 сая төгрөгөөр буюу 22.8 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,563.1 сая төгрөгөөр буюу 30.1 хувиар, хангамж, бараа материалын зардлыг 207.8 сая төгрөгөөр буюу 4 хувиар, эд хогшил, урсгалын засварын зардлыг 227.3 сая төгрөгөөр 4.4 хувиар, томилолтын зардлыг 37.8 сая төгрөгөөр буюу 0.07 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 436.4 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,216.5 сая төгрөгөөр 23.4 хувиар, бусад урсгал шилжүүлгийг 286.2 сая төгрөгөөр 5.5 хувиар хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хөрөнгийн зардлыг 6,636.6 сая төгрөгөөр буюу 20.8 хувиар хэмнэсэн нь Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сан, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээ огт хийгдээгүй, зарим төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй болон Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийг нээгээгүйгээс санхүүжилт дутуу олгогдсон зэрэгтэй холбоотой байна.

Эргэж төлөгдөх зээлийг 1,395.9 сая төгрөгөөр хэмнэсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг төлөвлөсөн хэмжээнд олгоогүйтэй холбоотой байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд төсвийг үр ашиггүй, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан 2,385.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

### Хүснэгт 10. Төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан зөрчил

(сая.төгрөгөөр)

№	Шалгагдагч байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Мөнгөн дүн
1	Алдархаан сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн золголт, говийн бүсийн спортын наадмын зардал, ЕБС болон нисэх хүчин үүсэн байгуулагдсаны ойн арга хэмжээний хандив, аймгийн арслан хүндэтгэл үзүүлэхэд эмээл худалдах авах зэрэгт 7,850.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	7.9
2	Асгат сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс нийтийн хог цэвэрлэгээ, ахмадын үйл ажиллагааг дэмжихэд 2,000,000 төгрөгийг, ЕБС-ийн сурагчдад "Эдүтэн" хөтөлбөрийн хүрээнд хоолны зардалд 500,000 төгрөгийг гаргаж батлагдсан төсвийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан байна.	2.5
3	Аймгийн БОАЖГ	Төсвөөс сургалт, үйл ажиллагаатай холбоотой 13.5 сая төгрөгөөр хоол хүнс, цайны материал худалдан авсан	13.5
4	Баянтэс сумын ЗДТГ	Санхүүгийн албаны ажилчдад балансын урамшуулал олгосон байна.	2.9
5	Баянтэс сумын ЗДТГ	Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний үндсэн ажилтны цалин хөлснөөс гадна санхүүгийн албаны даргад давхардуулан 40 хувийн нэмэгдлийг олгосон байна.	6.4

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

6	Баянтэс сумын ИТХ	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалт цалингийн тооцооллыг давтан шалгахад Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолыг зөрчсөн байна	4.0
7	Баянхайрхан сумын ЗДТГ	E-mongolia нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар тооцож, 4,404.4 мянган төгрөгийг илүү олгосон байна	4.4
8	Баянхайрхан сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 иргэнд гэр худалдаж авхад дэмжлэг үзүүлж 2,500,000 төгрөгийг гаргаж батлагдсан төсвийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан байна.	2.5
9	Дөрвөлжин сумын ЗДТГ	Хоршоо хөгжүүлэх санг хариуцан ажиллаж Хөдөө аж ахуйн мэргэжилтэндээ ажил хавсарсны нэмэгдэл олгосон	1.4
10	Аймгийн ЗДТГ	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, байгаль орчныг хамгаалах, туршлага судлах аялал жуулчлал хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг сурталчлахаар "Ажил гүйцэтгэх гэрээ", "Хамтран ажиллах гэрээ" байгуулж гэрээний заалтад гүйцэтгэх ажлын хэмжээ, стандарт, техникийн шаардлага, урьдчилгаа төлбөр олгох, гүйцэтгэлээр санхүүжүүлэх тухай гол нөхцөлүүдийг тодорхой тусгаагүй ерөнхий гэрээ байгуулж төлбөрийг бүрэн шилжүүлсэн. Гэрээ байгуулснаас хойших хугацаанд хийсэн ажлын тайлан, нотлох баримт, дутуу байна.	19.0
11	Идэр сумын ЗДТГ	Үндсэн ажлаа хийж байгаа албан хаагч нарт илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон	2.0
12	Аймгийн ИТХ	Тус байгууллагын батлагдсан төсвөөс Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжид үндэслэн 844.5 сая төгрөгийг зарцуулснаас аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлд тусгагдсан 216.7 сая төгрөгийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бус зарцуулсан байна.	216.7
13	Аймгийн ИТХ	Аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарын үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээнд 444.4 сая төгрөг зарцуулсан нь Засгийн газрын тогтоолоор баталсан жишиг хэмжээнээс хэтэрсэн бөгөөд үүний 175.0 сая төгрөгийг тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардалд 190.6 сая төгрөгийг гадаад улсын туршлага судлахад, 78.8 сая төгрөгийг дотоод туршлага судлах арга хэмжээнд зарцуулсан байна. Ингэхдээ гадаад улсад туршлага судлах ажлыг сургалтын чиглэлээр мэргэшсэн байгууллагатай хамтран зохион байгуулаагүй, аялалын компаниудтай хамтран хэрэгжүүлсэн, туршлага судлах арга хэмжээний зардлыг сургалтын үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн дансанд байршуулж, зарцуулснаар тайлагнасан	269.4
14	Аймгийн ИТХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, ажиллах журмыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр батлаагүй мөртлөө хоёр ажилтанг төрийн үйлчилгээний албан тушаалд томилж 14.1 сая төгрөгийн цалин олгосон	14.1
15	Аймгийн ИТХ	Улс төрийн намуудад санхүүжилт олгож, дэмжлэг үзүүлсэн	117.0
16	Аймгийн ИТХ	Улс, аймгийн аварга малчин, аймгийн сайн малчин, алтан төлийн эздэд аймгийн Засаг даргын нөөц сангаас бэлэг дурсгалын зардал гаргасан байхад тус байгууллагын төсвөөс давхар зардал гаргаж 4.6 сая төгрөгийн төсвийг үр ашиггүй зарцуулсан	4.6
17	Их-Уул сумын ЗДТГ	Засаг даргын тамгын газрын Архив бичиг хэргийн ажилтанд хүний нөөцийн хавсарсан ажилласны нэмэгдлийг олгосон байна. /20 хувь/	2.8
18	Яруу сумын ИТХ	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж усалгаажуулах арчлах зорилгоор цэцэрлэгт хүрээлэнгийн усалгаа арчилгааны 10,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар үрлэгэн зарцуулсан байна.	10.0
19	Их-Уул сумын ЗДТГ	Байгууллагын ажилчдад мэргэжил ангийн хувцас бэлтгэсэн байна.	5.8
20	Их-Уул сумын ЗДТГ	ЗДТГ-ын жолоочд ажил хавсарсны нэмэгдлийг давхардуулан авсан байна. /20 хувь/	2.3
21	Улиастай сумын ЗДТГ	"Дуртмал-Алтан" ХХК-д Тувагийн өдрүүд арга хэмжээний хүлээн авалтын зардал гаргасан /81102/	16.0
22	Улиастай сумын ЗДТГ	Байгууллагын албан хаагчдад туршлага солилцох сургалтыг УБ хотод зохион байгуулсан /шатахуун, буудлын хөлс, сургагч багшийн төлбөр, заалны түрээс зэрэгт зарцуулсан/ /81102/	15.0
23	Улиастай сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс батлагдсан төсөвтэй байгууллагуудад 64,889,420 төгрөгийн спорт, нийтийн цэвэрлэгээ, танхимын тохижилт, ойн арга хэмжээнд дэмжлэг олгосон байна.	64.9
24	Улиастай сумын ЗДТГ	Төсвөөс сургалтын төлбөр төлсөн /удирдлагын академи, архивын ерөнхий газар/	8.1
25	Улиастай сумын ЗДТГ	Төсвөөс спорт заалны түрээс төлсөн байна.	0.8
26	Улиастай сумын ИТХ	Төлөөлөгчдийн үйл ажиллагаандаа зарцуулах төсвийг адил тэгш олгоогүй, 8,000,000 төгрөгийг илүү олгосон байна.	8.0
27	Улиастай сумын ИТХ	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга хувийн автомашинаар хот дотор 1,000,000 төгрөгийн, байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажилд 500,000 төгрөгийн шатахуун тус тус зарцуулж нь өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.	1.5
28	Ургамал сумын ИТХ	Эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 35 хувиар тооцож 2,631,006 төгрөгийг илүү олгосон байна.	2.6
29	Ургамал сумын ИТХ	Төсвөөс "Пи эс дабль" ХХК-д туршлага солилцох нэрийдлээр аялалын зардал шилжүүлэн, үр дүнгүй зардал гаргасан.	3.5
30	Цагаанхайрхан сумын ЗДТГ	Цагаан сарын бөхийн барилдаан, татвар төлөгчдийн өдөр зэрэг арга хэмжээ зохион байгуулж, төсөвт байгууллагын албан хаагчид шагнал, урамшуулал олгон төсвийг зориулалт бусаар зарцуулсан	3.4
31	Шилүүстэй сумын ИТХ	ИТХ-ийн төлөөлөгчдийн чадвахижуулах сургалт зохион байгуулж, төсвөөс сургалтын зардлыг нь төлсөн	0.9

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

32	Яруу сумын ИТХ	Шатахууныг замын хуудасгүй, үрэлгэн зарцуулсан	11.0
33	Сонгино сумын ЗДТГ	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас 1.8 төгрөгийн хүүхдийн баярын бэлэг худалдан авч, бараа үйлчилгээний бусад зардлаас "Дөл-2025" тэмцээнд оролцогчдын хувцасны үнэ 1.6 төгрөгийг төлж, батлагдсан төсвийг зориулалт бусаар үрэлгэн зарцуулсан;	3.4
34	Түдэвтэй сумын ЗДТГ	3 хотод золголт зохион байгуулж үргүй зардал гаргасан	8.7
35	Шилүүстэй сумын ЗДТГ	Архив албан бичгийн ажигчид журам зөрчиж зэргийн нэмэгдэл олгосон	2.8
36	Шилүүстэй сумын ЗДТГ	Төрийн дээд шагналаар шагнагдсан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон	1.9
37	Шилүүстэй сумын ЗДТГ	Засаг даргын нөөц хөрөнгөөс төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулахгүй байх, төсвөөс хоол хүнсний материал худалдан авч зориулалт бус зардал гаргасан	3.7
38	Яруу сумын ЗДТГ	Засаг даргын Тамгын газрын төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал гаргасан	1.0
39	Яруу сумын ЗДТГ	Татвар төлөгчдийн өдөр, уулзалт сургалтын зардал гаргаж төсвийг зориулалт бус зарцуулсан	3.6
40	Авто замын сан	Автозамын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	59.8
41	Аймгийн ОНХС	Отгор нүүдлээр яваа малчдад эрүүл мэнд болон төрийн үйлчилгээ үзүүлэх, Төрийн бус байгууллага, Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, Завхан аймаг "Баруун бүсийн аялал жуулчлалын төв" болох зорилтыг хэрэгжүүлж "Шашны аялал жуулчлал"-ыг хөгжүүлэх, Гадаад улс орнуудтай хийх хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулах, гэрээ санамж бичиг байгуулах, "Шашны аялал жуулчлал"-ыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд контент хийх зэрэг Орон нутгийн хөгжлийн сангийн журам зөрчсөн, зориулалт бус арга хэмжээнд нийт 288.5 сая төгрөгийг төлөвлөж зарцуулсан;	288.5
42	Аймгийн ОНХС	Насан туршийн суралцахуйн төвөөр дамжуулан малчид, бизнес эрхлэгчид, хоршоологчдыг дэмжиж сургалтад хамруулах, Завхан аймгийн Бизнес кластер, Шинжлэх ухаан инновацыг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх, Гадаад улс орнуудтай хийх хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлж, олон талт арга хэмжээг зохион байгуулах, гэрээ санамж бичиг байгуулах зэрэг Орон нутгийн хөгжлийн сангийн журам зөрчсөн арга хэмжээнд төлөвлөж, 259.5 сая төгрөгөөр малчид болон Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежерийг гадаадад аялуулсан байна.	259.5
43	Улиастай сумын ОНХС	Боловсролын байгууллагуудад дэмжлэг олгосон байна.	35.0
44	Шилүүстэй сумын ОНХС	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр малчдын зөвлөгөөн зохион байгуулж, тэмцээний шагнал, хоол хүнсний материалд 8.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	8.5
45	"ОЧИР-ИЛЧ" ОНӨААТҮГ	Байгууллагын төсвөөс спорт уралдаан тэмцээн, шагнал урамшуулал, ажиллагсдын хурим, сэвлэг үргээх ёслол, сургалт, хоолны зардал гарган төсвийг зориулалт бусаар зарцуулсан	7.4
46	"ОЧИР-ИЛЧ" ОНӨААТҮГ	Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 1 орон тоог 2 орон тоо гэж үзэн хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 20 хувийг ТУЗ-ийн шийдвэргүйгээр олгосон	4.4
47	Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх теле камерын хяналтын дэд төв	Хоол, унааны нэмэгдэл хөлсийг тушаал шийдвэрээс 4,734.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.	4.7
48	ОНХО	Хөрөнгө оруулалтын зардлаас төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор тэтгэмж, уралдаан тэмцээний урамшуулал, тэтгэлэг зэрэгт төсвийн хөрөнгийг үр ашиггүй үрлэгэн зориулалт бусаар зарцуулсан байна.	847.8
<b>Дүн</b>			<b>2,385.7</b>

**Засаг даргын ерөнхий дансны төлөвлөлт, зарцуулалт:** Засаг даргын ерөнхий дансанд 2025 онд 6 хөтөлбөрт 6,378.7 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 5,769.3 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- 70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт хөтөлбөрт 3,194.6 сая төгрөг;
- 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрт 353.1 сая төгрөг;
- 71101-Авто зам хөтөлбөрт 1,089.9 сая төгрөг;
- 71105-Авто тээврийн хяналт, зохицуулалт хөтөлбөрт 30.0 сая төгрөг;
- 71701-Биеийн тамир спорт хөтөлбөрт 913.7 сая төгрөг;
- 72208 Ахмад настны хөгжил хамгаалал хөтөлбөрт 188.0 сая төгрөг тус тус зарцуулжээ.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс Засаг даргын ерөнхий дансыг төсвийн төлөвлөлттэй холбоотойгоор бий болсон гэх тайлбарыг өгсөн боловч тус дансаар зарцуулалт хийх хууль, журмын зохицуулалт байхгүй байна. Иймд Засаг даргын ерөнхий дансны зарцуулалтыг тодорхой болгох, эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна. Тус дансанд

арга хэмжээний зардал төлөвлөж, зориулалт бусаар зарцуулсан зөрчилд ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгсөн байна.

**Санхүүгийн тайлангийн аудитын 2025 оны ерөнхий чиглэлийн судалгааны нэгтгэл, дүн шинжилгээ хийсэн байдал:**

**Унаа, хоолны хөнгөлөлтийн зардал-210103:** ТЕЗ-ийн харьяа төсөвт 66 байгууллагаас 12 байгууллага унаа, хоолны хөнгөлөлт олгож байна. Судалгааны үр дүнгээс харахад унаа, хоолны хөнгөлөлтийг 1,118.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 846.7 сая төгрөг байгаа ч 5 байгууллага төлөвлөгөөнөөс нийт 85.0 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна. Унаа, хоолны хөнгөлөлтийг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8, 61.1.1, 61.1.3 дахь заалт, мөн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгож журам” болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг тус тус үндэслэн олгож байна. Унаа, хоолны хөнгөлөлтийн үнэ арифьыг 5.0-25.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Улиастай сумын хот тохижилт үйлчилгээний албаны унаа, хоолны хөнгөлөлтийн үнэ тариф зах зээлийн үнэтэй харьцуулахад бага бусад байгууллагын хувьд боломжийн хэмжээнд байна гэж дүгнэлээ.

**Гадаад томилолт, арга хэмжээний зардал:** ТЕЗ-ийн харьяа 2 байгууллага гадаад томилолт, арга хэмжээний зардлыг 194.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 139.3 сая төгрөг зарцуулсан байна. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 190.6 сая төгрөгийн зөрчилд төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байхаар албан шаардлага өгсөн.

**Төрд учирсан хохирол барагдуулах зардал:** ТЕЗ-ийн харьяаны 1 байгууллага 60.7 сая төгрөгийг олгосон байна. Буруу шийдвэр гаргасан албан тушаалтан өөр албан тушаалд шилжин томилогдсон бөгөөд төрд учирсан хохирлыг барагдуулж ажиллахаар холбогдох байгууллагад албан шаардлага өгсөн байна.

**Программ хангамжийн бүртгэл:** ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нийт 132.8 сая төгрөгийн 107 программ байна. Үүнээс өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг 50, ашигладаггүй 57, байгууллагын данс бүртгэлд тусгасан 97.5 сая төгрөгийн 78, тусгаагүй 29 программ байна.

**Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал:** ТЕЗ-ийн харьяа 10 байгууллага сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд төсвөөс 170.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс 11.6 хувь буюу 19.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь тайлан хугацаанд төлөвлөөгүй арга хэмжээ байна.

**ТБОНӨ хуулийн этгээд:** ТЕЗ-ийн харьяаны ОНӨААН-ийн судалгаанаас үзэхэд 11 байгууллагын тайлант хугацааны нийт орлого 6,492.0 сая төгрөг, зардал 7,264.7 сая төгрөг байна. Харьяа ОНӨААН-дд 725.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд 2 байгууллага 153.6 сая төгрөгийн найдваргүй авлагатай байна.

**Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл:** ТЕЗ-ийн харьяаны 4 байгууллага холбогдох зардлаас 86.6 сая төгрөгийг зарцуулахаар 10 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 51.9 сая төгрөг зарцуулсан байна. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар тус зардалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд зориулалт бус зарцуулалттай 2,385.7 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, батлагдсан төсвийг үр ашиггүй, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан зөрчил буурахгүй, жил бүр давтагдан гарсаар байна. Иймд аймгийн засаг даргад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

**2.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 22 хөтөлбөрөөс 15 хөтөлбөр 90-100 хувь, 7 хөтөлбөр 58-89.5 хувийн хэрэгжилттэй байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай байгаа нь Монгол Улсын эдийн засаг хүндэрсэнтэй холбогдуулан Сангийн яамнаас зарцуулах эрхийг хязгаарласнаар зарим зардлыг зарцуулаагүйгээс шалтгаалсан байна.

**Хүснэгт 11. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөрөөр**

*(сая төгрөгөөр)*

д.д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	6,600.8	5,962.8	637.9	90.3%
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	30,303.9	27,654.3	2,649.6	91.3%
3	70417 Мэргэжлийн хяналт	399.3	377.6	21.7	94.6%
4	70418 Худалдан авах ажиллагаа	337.2	332.6	4.6	98.6%
5	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлж	379.5	363.3	16.2	95.7%
6	70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	30,327.4	23,810.8	6,516.5	78.5%
7	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	443.8	353.0	90.7	79.6%
8	71101 Авто зам	1,218.0	1,089.9	128.1	89.5%
9	71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт	30.0	30.0	-	100%
10	71403 Ойжуулалт	430.7	417.2	13.5	96.9%
11	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2,030.8	1,988.4	42.3	97.9%
12	71502 Хот байгуулалт, тохижилт	1,791.5	1,791.5	-	100%
13	71601 Нийгмийн эрүүл мэнд	170.2	167.5	2.6	98.5%
14	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	3,224.0	2,940.2	283.8	91.2%
15	71701 Биеийн тамир спорт	1,028.7	913.7	115.0	88.8%
16	71702 Соёл урлаг	2,029.8	1,685.0	344.8	83.0%
17	71801 Сургуулийн өмнөх боловсрол	2,402.0	2,192.8	209.2	91.3%
18	71802 Ерөнхий боловсрол	9,081.6	8,416.4	665.2	92.7%
19	71804 Мэргэжлийн боловсрол	867.7	825.8	41.9	95.2%
20	71902 Нийгмийн халамж	211.7	159.5	52.2	75.4%
21	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	188.0	188.0	-	100%
22	72210 Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэлт	3,337.8	1,941.8	1,395.9	58.2%
<b>Дүн</b>		<b>96,834.3</b>	<b>83,602.3</b>	<b>13,232.0</b>	<b>86.3%</b>

ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөрийн ангиллаар авч үзвэл нийт гүйцэтгэлийн 7.1 хувийг Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, 33.1 хувийг Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, 29.8 хувийг орон нутгийн хөрөнгө оруулалт, 2.4 хувийг хүрээлэн буй орчны бодлого удирдлага, 2.1 хувийг Хот байгуулалт, тохижилт, 0.5 хувийг ойжуулалт, бусад 16 хөтөлбөрт 25 хувийг зарцуулсан байна.

**Хүснэгт 12. Хөтөлбөрийн хэрэгжилт**

№	Хөтөлбөрийн хэрэгжилт					
	100 хувь	90-ээс дээш хувь	80-аас дээш хувь	70-аас дээш	60-аас дээш хувь	50-аас дээш хувь
Хөтөлбөр	3	12	3	3	-	1

**ТЕЗ-ийн хүрээнд хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл 79.2 хувьтай байгаа нь нэгдсэн төсвийн гүйцэтгэл буурахад гол нөлөө үзүүлсэн байна.**

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой нийт 3,891.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,262.4 сая төгрөг нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй, 988.3 сая төгрөг нь худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, 690.6 сая төгрөг нь иргэдээс санал авч эрбэлээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, 305.3 сая төгрөг нь ОНХС-ын журам зөрчсөн төсөл арга хэмжээг төлөвлөж, зарцуулсан, 218.3 сая төгрөг нь хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг шилэн данс болон удирдлагын мэдээллийн системд ил тод мэдээлээгүй, 208.7 сая төгрөг нь ОНХС-ын хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 209.3 сая төгрөг нь ИТХ-аар батлуулаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн, 9.0 сая төгрөг нь анхан шатны баримт дутуу зэрэгтэй тус тус холбоотой зөрчил байна.

График 4. Хэрэгжээгүй төсөл арга хэмжээ

(сая төгрөгөөр)



Тайлант онд нийт хөрөнгийн зардлыг 6,636.6 сая төгрөгөөр буюу 20.8 хувиар хэмнэсэн бөгөөд Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сан, аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээ огт хийгдээгүй, зарим төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн дуусаагүй болон Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийг нээгээгүйгээс үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

**Хоршоо хөгжүүлэх сан:** Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 1,451.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Тайлант онд 24 сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 3,337.7 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж, 1,941.8 сая төгрөгийн зээл олгож, гүйцэтгэл 58.1 хувьтай байна. Гүйцэтгэл бүрэн хангагдаагүй нь олгосон зээл хугацаандаа төлөгдөөгүйгээс зээлийн эх үүсвэр бүрдээгүй, сумдад шаардлага хангасан хоршоо оролцдоггүй, хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөлтийг бодитой хийдэггүй зэргээс шалтгаалж байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэлийг сүүлийн гурван жилийн байдлаар авч үзэхэд Завханмандал, Сонгино, Ургамал, Цэцэн-Уул сумдын авлага тогтмол буурсан бол Алдархаан, Их-Уул, Сантмаргаз, Түдэвтэй сумдын авлага тогтмол өссөн байна.

Хүснэгт 13. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага

(сая.төгрөгөөр)

д/д	Сумын нэр	2023 он	2024 он	2025 он	Дүнд эзлэх хувь
1	Алдархаан	196.7	244.9	266	5%
2	Асгат	169.7	158.6	181	3%
3	Баянтэс	159.3	147.3	189.6	4%
4	Баянхайрхан	188.7	155.2	207.7	4%
5	Дөрвөлжин	165.8	58.1	76.8	1%
6	Завханмандал	170.3	126.3	53.6	1%
7	Идэр	181.2	178.2	187.5	4%
8	Их-Уул	280.4	285.2	288.1	5%
9	Нөмрөг	169.5	177.6	111.8	2%
10	Отгон	188	86.2	95.1	2%
11	Сантмаргаз	130.9	161.3	162.8	3%
12	Сонгино	130.7	105.4	86	2%
13	Тосонцэнгэл	473.4	558.5	556.4	11%
14	Тэс	181.6	94.6	199.9	4%
15	Түдэвтэй	191.4	193.1	207.5	4%
16	Тэлмэн	167.7	89	160.1	3%
17	Улиастай	808.7	785.6	921.5	17%
18	Ургамал	112.4	79.2	59.5	1%
19	Цэцэн-Уул	192.8	170.7	159.7	3%
20	Цагаанхайрхан	151	128.3	242.3	5%

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

21	Цагаанчулуут	226.8	215.1	223.5	4%
22	Шилүүстэй	200.9	176.1	233.9	4%
23	Эрдэнэхайрхан	218.1	157.3	246.7	5%
24	Яруу	154.2	205.2	160	3%
<b>Нийт дүн</b>		<b>5,210.20</b>	<b>4,737.00</b>	<b>5,277.00</b>	<b>540</b>

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой нийт 478.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнээс 425.6 сая төгрөг нь зээлийн үлдэгдэл маргаантай, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, 41.5 сая төгрөг нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, 10.9 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн дансанд байгаль хамгаалах сан болон барьцаа хөрөнгийн орлого байршуулсан зэрэг зөрчилтэй тус тус холбоотой байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл маргаантай, зээл авсан өдрөөс хойш огт төлөлт хийгээгүй, зээлдэгчийн зээлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй Алдархаан, Асгат, Баянтэс, Завханмандал, Отгон, Сонгино, Тосонцэнгэл, Цэцэн-Уул сумдууд, малжуулах зээлд хамрагдсан иргэдийн зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй болон өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй Баянхайрхан, Завханмандал, Эрдэнэхайрхан, Яруу сумдын хоршоо хөгжүүлэх сангийн зөрчил байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 11 сумын Хоршоо хөгжүүлэх санд 478.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 36.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 441.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна. Зээлийн үлдэгдэлтэй ч зээлээ бүрэн төлсөн гэх маргаантай асуудлыг бүрэн цэгцэлж, Сангаас зээл авснаас хойш эргэн төлөлт огт хийгээгүй зээлдэгч нарын зээлийг төлүүлэх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

**График 5. (сая төгрөгөөр)**



Хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөлтийг бодитой, тооцоололтой хийгээгүйгээс төлөвлөсөн хэмжээнд зээл гаргах боломжгүй нөхцөл үүсэж, гүйцэтгэл 58.2 хувьтай байгаа нь нэгдсэн төсвийн гүйцэтгэл буурахад гол нөлөө үзүүлсэн байна. Иймд Хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөлтийг бодит тооцоололд үндэслэн хийж, гүйцэтгэлийн бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

### **Аудитын илрүүлэлт:**

*Хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөлтийг бодитой, тооцоололтой хийгээгүй зөрчилд сумдын Засаг дарга нарт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.*

**Нэмэлт төсвийн гүйцэтгэл**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 34 байгууллага тайлант онд нэмэлтээр нийт 6,222.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 33.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 14. Нэмэлт санхүүжилтийн орлого**

*(сая.төгрөгөөр)*

№	Орлогын төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,326.1	1,098.7
2	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	982.8	1,454.7
3	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,110.8	3,669.2
<b>ДҮН</b>		<b>9,419.7</b>	<b>6,222.6</b>

Нэмэлт санхүүжилтийн дансаар авто замын сан, орон нутгийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-аас эрх шилжсэн ажлын санхүүжилт, архивын гэрээт ажилчдын цалин, шимтгэл, сумдын ЗДТГ-уудын усны орлого дамжсан байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 11 байгууллага 1,454.7 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 32 байгууллага 3,669.2 сая төгрөгийн, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6 байгууллага 1,098.7 сая төгрөгийн, нийт 6,222.6 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, эд хогшил урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг урсгал зардалд 5,358.4 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 864.2 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд эрх шилжсэн хөрөнгө, нэмэлтээр олгосон санхүүжилттэй холбоотой 189.0 сая төгрөгийн зөрчил илэрч, албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

**БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ИХ ЗАСВАР, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ**

**ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛААС 2025 ОНД 5,662.4 САЯ ТӨГРӨГИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХАСАЖ, ТОДОТГОН БАТАЛЖЭЭ.**

**3.1 Завхан аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө нь бодлогын баримт бичгүүдтэй уялдсан, хэрэгжилтийн явц тогтвортой, зарим салбарт тодорхой ахиц үр дүн гарсан бөгөөд нийт дүнгээрээ 90.1 хувьтай байна.**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2024 оны 21 дүгээр тогтоолоор аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталж, 4 бүлгийн хүрээнд 31,648.7 сая төгрөгийн 188 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр, 3,461.0 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээг хасаж, аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн барилгад их засвар хийх 980.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг нэмж баталсан байна. Үүнд:

- Бүсчилсэн хөгжлийн бодлогын (хөрөнгө оруулалт) хүрээнд 65 арга хэмжээ
- Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 36 арга хэмжээ
- Эдийн засгийн бодлогын хүрээнд 45 арга хэмжээ
- Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд 42 арга хэмжээ тус тус байна.

“Аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай” аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 46 дугаар тогтоолоор тодотгол хийж, 26,746.3 сая төгрөгийн 170 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр, 5,662.4 сая төгрөгийн 28 төсөл арга хэмжээг хасаж, 835.9 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг нэмж баталсан байна .

Хасагдсан төсөл арга хэмжээг тодруулбал 4,549.4 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх боломжгүй, 696.0 сая төгрөгийн 4 төсөл арга нь хэмжээ төсвийн тодотголтой холбоотой, 417.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь зураг төсөл ирээгүй, худалдан авах ажиллагаа зарлагдаагүй, хэрэгжээгүйтэй холбоотой тус тус хасагдсан байна.

График 6. Хасагдсан төсөл арга хэмжээ (сая төгрөгөөр)



Мөн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 2,620.6 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ, Их засвараас хийгдэх 2,264.3 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 677.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээ, Орон нутгийн төсвөөс хийгдэх 100.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг тус тус хасаж баталсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 46 дугаар тогтоолоор 835.9 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг нэмж баталснаас 270.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг Орон нутгийн хөрөнгө оруулалтаас, 300.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангаас, 265.9 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

**Нэмж тусгасан төсөл арга хэмжээний жагсаалт:**

1. Гадаадын иргэн харьяатын газрын баруун бүс дэх газарт автомашин авах;
2. Арц суурь боомтын албан хаагчдын зөөврийн орон сууц худалдан авах;
3. Арц суурь боомтын сэргэлт арга хэмжээ хэрэгжүүлэх;
4. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох;
5. АДАПТ төслийн орон нутгийн талын санхүүжилт;
6. Бохир усны авто машинд лаг соруулах тоноглол авах;
7. Теле хяналтын дэд төвийн үйл ажиллагааны зардлыг олгох;
8. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх;

Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнөөс хассан нийт арга хэмжээний 80.3 хувийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх боломжгүй гэх шалтгаанаар хасаж, хөрөнгө худалдан авахтай холбоотой 590.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, үйл ажиллагааны арга хэмжээтэй холбоотой 245.9 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ нэмж баталсан нь төлөвлөлт хангалтгүй, төсвийг зохистой, үр дүнтэй удирдахгүй байгааг харуулж байна.

**Хүснэгт 15. Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө, санхүүжих эх үүсвэрийн жагсаалт**

ДД	Эх үүсвэр	Арга хэмжээний тоо	Санхүүжилт (сая төг)	Эзлэх хувь
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	55	7,008.6	26%
2	Орон нутгийн хөгжлийн сан	45	5,657.9	21%
3	Орон нутгийн төсөв	33	3,465.7	13%
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	2,478.0	9%
5	Их засвар	12	2,117.0	8%
6	Төсөл хөтөлбөр	3	1,830.5	7%
7	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан	1	1,500.0	6%
8	Крон нутгийн замын сан	6	1,218.0	5%
9	Байгууллагын өөрийн хөрөнгө	4	1,124.1	4%
10	Цэргийн мөнгөн төлбөр	8	161.5	1%
11	Сумын Засаг даргын Тамгын газар	1	123.0	0%
12	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал	3	62.0	0%
<b>Нийт дүн</b>		<b>175</b>	<b>26,746.3</b>	<b>100%</b>

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Завхан аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2025 оны 50 дугаар тогтоолоор 170 арга хэмжээний хүрээнд 93.4 хувийн биелэлттэй буюу “Үр дүнтэй” гэж дүгнэжээ.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 170 төсөл арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 1 төсөл арга хэмжээ 30 хувь, 5 төсөл арга хэмжээ 50 хувь, 4 төсөл арга хэмжээ 70 хувь, 11 төсөл арга хэмжээ 90 хувь, 147 төсөл арга хэмжээ 100 хувь тус тус биелэлттэй байна.

**Хүснэгт 16. Хэрэгжилт хангалтгүй болон дутуу гүйцэтгэлтэй төсөл арга хэмжээний хэрэгжилтийн жагсаалт** (сая төгрөгөөр)

№	Үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээ	Төсөв	Зарцуулсан хөрөнгө	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн Хувь
1	Арц суурь боомтын албан хаагчдын амьдрах байр барих	110.0		Худалдан авах ажиллагаа 2 дахь удаа зарлагдсан.	0
2	Монгол Улсад цэргийн дээд цол генерал цол олгож эхэлсний 81 жилийн ойг угтаж иргэд олон нийтэд алтан мөрдөст эрхэм генералуудын үйл хэрэг, байгуулсан гавьяа, амжилт бүтээлийг сурталчлан алдаршуулах зорилгоор “Монгол цэрэг” дууны уралдаан зохион байгуулах	5.0		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх боломжгүй болсон.	0
3	Бэлчээрийн менежментийн үйл ажиллагааны хүрээнд хадлан тэжээлийн нөөц газар байгуулах	253.9	40.0	"Энхмөнх-Ирээдүй" ХХК шалгаран гэрээ байгуулагдсан. 6 суманд хийгдэхээс 2 суманд хийгдсэн. Алдархаан, Шилүүстэй сумдын 31.0 га талбайг хашсан, бусад сумдын материал татан авалт хийгдсэн. Орон нутгийн талын санхүүжилт саатсантай холбоотойгоор ажил түр хүлээгдсэн.	30
4	Улиастай сумын Товцог багт халуун ус, нийтийн ахуйн үйлчилгээний төв байгуулах	450.0	199.7	Улиастай сумын ЗДТГ-т тендер зарлагдаж гүйцэтгэгчээр "Ганбүрэн" ХХК шалгаран гэрээ хийгдэж, газар шороо, суурь, гадна ханын өрлөг, хавтгай дээвэр, дотор ханын шавардлага хийгдэж байна.	50
5	Алдархаан сумын Чигэстэй багт Иргэдийн хөгжлийн төв барих	87.0	60.9	"Ган доной" ХХК Алдархаан сумын Чигэстэй багийн иргэдийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Суурь, хана, хучилт хийгдсэн.	50
6	Хөдөлмөрт бэлтгэх сургалт зохион байгуулах	60.0	8.9	Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалтад 60 иргэн, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх болон дараах сургалтад 105 иргэн, суурь чадварын сургалтад 50 иргэн, нийт 215 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулсан.	50
7	Завхан аймгийн Бизнес кластер, Шинжлэх ухаан инновацыг хөгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх	200.0	108.8	БНСУ-д "Боловсролын цахим шилжилт" шинжлэх ухаан инновацийг хөгжүүлэх сургалт арга хэмжээнд боловсролын салбарын холбогдох албан хаагчдыг хамруулсан. Мөн БНХАУ-д уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох туршлага, инновац"-ыг судлах чиглэлээр салбарын 3 албан тушаалтныг мэргэшүүлэх 14 хоногийн сургалтад хамруулж чадавхжуулсан.	50
8	Татмын ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх	556.9	556.9	Алдархаан, Отгон, Завханмандал сумдад 50 га, Эрдэнэхайрхан, Сантмаргаз, Яруу, Цэцэн-Уул сумдад 60 га талбайд "Отгон	50

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

				баян уул" ХХК, Баянтэс, Тэс, Тосонцэнгэл сумдад 40 га талбайд Алтан солин ХХК татмын ойжуулалт хийх гүйцэтгэгчээр шалгарч Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай гэрээ байгуулсан. Хамгаалалтын хайс хашааг бүрэн барьж дууссан. Адапт төслийн төслийн санхүүжилт 2026 онд олгогдохоор болж мод тарилтын ажлыг ирэх хавар хийхээр хойшлогдсон.	
9	Тэлмэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	127.0	50	Тэлмэн сумд эрх шилжиж, сумын ЗДТГ-т тендер зарлагдаж, гүйцэтгэгчээр "Циркул проект" ХХК шалгарч сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна.	70
10	Улиастай сумын Өлзийт багт 160 айлын орон сууц, хаус хорооллын инженерийн шугам сүлжээ барих, ЦДШ татах	98.7	0	Улиастай сумын Өлзийт багийн 160 айлын орон сууц, хаус хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг "Таван тайхар" ХХК гүйцэтгэсэн. Цэвэр, бохир, дулааны шугам сүлжээний ажил хийгдэж байна.	70
11	Отор нүүдлээр яваа малчдад эрүүл мэнд болон төрийн үйлчилгээ үзүүлэх	30	30	Гадны 4 аймгийн нутагт 3 сумын 31 өрх оторлохоор урьдчилсан судалгаа гарсан. Мөн отрын бүс нутагт өвөлжих өрх, малын хүсэлтийг 8 сумын 162 өрхийн (51.3 мянган толгой мал) 542 хүний мэдээллийг ирүүлсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын ЭМТ-үүд отор нүүдлээр яваа малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг алсын болон ойрын дуудлагаар үзүүлж байна. Цаашид өвөлжилт хүндрэх, гамшиг ослын үед алслагдсан сум, багийн иргэдэд явуулын үзлэг, оношлогоо хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	70
12	Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх	450	201	150,0 сая төгрөгт 150тн малын хивэг тэжээл худалдан авах тендерт "Начин трейд"ХХК шалгаран гэрээ байгуулагдсан. Аймгийн аюулгүйн нөөц 6 сумд хуваарийн дагуу хүргүүлнэ. 202,0 сая төгрөгт 144 тн буюу 8000 боодол байгалийн хадлан авах тендерт "Асгат буудай" ХХК шалгаран заасан байршлуудад хүргүүлэхээр гэрээ байгуулан өвс нийлүүлэгдсэн.	70
<b>Нийт дүн</b>		<b>2,428.5</b>	<b>1,256.2</b>		

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт 88.2 хувийн биелэлттэй тул “**Үр дүн гарсан**” гэж дүгнэсэн байна.

**Хүснэгт 17. Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн жагсаалт** (сая.төгрөгөөр)

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	1	7	92.80%
2	Хүний хөгжил	4	21	94.10%
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	5	31	86.30%
4	Эдийн засаг	3	16	76.60%
5	Засаглал	2	5	91.10%
6	Ногоон хөгжил	4	12	87.50%
7	Батлан хамгаалах	4	11	95.00%
8	Бүс, орон нутгийн хөгжил	3	14	82.40%
<b>Нийт дүн</b>		<b>26</b>	<b>117</b>	<b>88.20%</b>

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

“Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндэн чиглэлийн хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 5 үндсэн чиглэлийн хэрэгжилт хангалтгүй буюу 30-50 хувийн, 27 үндсэн чиглэл 70 хувийн, 41 үндсэн чиглэл 90 хувийн, 45 үндсэн чиглэл 100 хувийн тус тус биелэлттэй байна.

**“Хангалтгүй” хэрэгжсэн үндэслэж байгаа бодлогын баримт бичгийн жагсаалт:**

1. Үерийн эрсдэлээс хамгаалах өрхийн тоог нэмэгдүүлнэ-30 хувьтай
2. Төв, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боовруулна-30 хувьтай
3. Орон нутгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд чиглсэн үйл ажиллагаа явуулна-50 хувьтай
4. Дайвар бүтээгдэхүүн худалдан авах цэгүүд, боловсруулах цех байгуулна-50 хувьтай
5. Төрийн үйлчилгээний чанрын стандартыг бий болгож, төрийн үйлчилгээнд иргэд олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүлнэ-50 хувьтай хэрэгжсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолоор Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт 88.7 хувийн биелэлттэй тул **“Үр дүнтэй”** гэж дүгнэсэн байна.

**Хүснэгт-18: Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн жагсаалт** (сая.төгрөгөөр)

№	Бүлэг	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Хот төлөвлөлт	10	79.3%
2		Эх үүсвэр инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл	13	76.6%
3		Дахин төлөвлөлт орон сууцжуулалт	8	87.5%
4		Барилга, барилгын материалын үйлдвэрлэл	2	100.0%
<b>Дүн</b>			<b>33</b>	<b>85.3%</b>
5	Хүний хөгжлийн бодлого	Гэр бүл хүн амын онцлогт нийцсэн бодлого	20	94.3%
6		Хөдөлмөр эрхлэлт	4	87.5%
7		Нийгмийн даатгал	4	100.0%
8		Эрүүл идэвхитэй амьдралын хэв маяг	11	78.1%
9		Тэгш хүртээмжтэй чанартай боловсрол	8	90.0%
10		Мэдлэг чадварай мэргэжилтэй	2	60.0%
11		Багшлах хүний нөөц	1	100.0%
12		Цахимжсан боловсрол	1	30.0%
13		Нийгмийн эрүүл мэнд	15	89.3%
14		Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж	11	97.2%
15		Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн, чанар хүртээмж	7	100.0%
16		Эрүүл мэндийн салбарын хүний нөөц	5	98.0%
<b>Дүн</b>			<b>89</b>	<b>86.6%</b>
17	Эдийн засгийн бодлого	Санхүү банк даатгалын байгууллагын шинэчлэл	1	100.0%
18		Татвар	4	92.5%
19		Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин	8	85.0%
20		Боомтыншинэчлэл, тээвэр, ложистик	7	100.0%
21		Хөдөө аж ахуй, шинэ хоршоо хөдөлгөөн, чинээлэг малчин хөтөлбөр	20	88.5%
22		Дөрвөн улирлын аялал жуулчлал	6	83.3%
23		Соёл урлаг, сочлын өв уламжлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл	7	94.2%
24		Шинэжлэх ухаан, технологи, инновац	5	80.0%
25		Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент	21	79.0%
26		Уур амьсгалын өөрчлөлт	10	63.0%

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Дүн			89	86.6%
27	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	Хүний эрх	2	100.0%
28		Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа	1	100.0%
29		Ил тод байдал хяналт	9	94.4%
30		Авилга, гэмж хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа	10	93.0%
31		Цахим засаглал, төрийн бүтээмж	9	87.7%
32		Харилцаа холбоо, мэдээлэл технологи	1	90.0%
33		Төрийн албаны шинэчлэл	14	100.0%
35		Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцоо	22	99.5%
36		Гамшгийн үеийн бэлэн байдал	2	100.0%
Дүн			83	96.3%
Нийт дүн			294	88.7%

**БҮЛЭГ 4. ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСВИЙН БОДЛОГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙГАА Ч ШАТ, ШАТНЫ ТӨСӨВ ЗАХИРАГЧИД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**4.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,473.1 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд үзэхэд 1,473.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 22.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,446.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

**Хүснэгт 19. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчил**

/сая.төгрөгөөр/

№	ТХТХ-н заалт	Зөрчил гаргасан товч утга	Мөнгөн дүн	Аудитын шийдвэр
1	10.2	Ёс зүйн хорооны гишүүдэд 2,138.4 мянган төгрөгийн урамшуулал олгож, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна.	2.1	Төлбөрийн акт
2	15.1.8	Төсвөөс "Иргэдийн спортын наадам"-д 1,500,000 төгрөгийн зардал гаргасан	1.5	Албан шаардлага
3	11.1	Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчид 750,000 төгрөгийн тэтгэмж давхардуулж олгосон, мөн орон тооны цомхотголоор ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид 315,000 төгрөгийн тэтгэмж илүү тооцож олгосон байна.	1.1	Төлбөрийн акт
4	15.1.8	Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан, хуульд зааснаас өөр хэлбэрээр шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон.	1.5	Албан шаардлага
5	15.1.2	Өмнөх аудитаар илэрсэн орон тооны зөвлөх ажиллуулж цалин урамшуулал олгосон зөрчлийг давтан гаргасан	2.0	Төлбөрийн акт
6	15.1.8	Албан хаагчдад үр дүнгийн урамшууллаас гадна 1.6 сая төгрөгийн нэмэлт шагнал, урамшуулал олгосон, Спорт заалны түрээс болон фитнесийн сургалтын төлбөрт 2.1 сая төгрөг төлсөн	3.7	Албан шаардлага
7	15.1.3	Жавхлант СӨХ-д жил бүр дэмжлэг олгосон /81102/	65.3	Албан шаардлага
8	15.1.8	Засаг даргын нөөц хөрөнгөөс спортын арга хэмжээ санхүүжүүлж, дэмжлэг үзүүлсэн	31.1	Албан шаардлага
9	15.1.4	Төсвөөс видео контент бэлтгэсэн байна.	2.0	Төлбөрийн акт
10	15.1.5	Төсвөөс мөнгөн аяга худалдан авсан	2.8	Төлбөрийн акт
11	15.1.8	Байгууллагын төсвөөс спорт, урлагийн уралдаан тэмцээн зохион байгуулан дэмжлэг үзүүлсэн	2.7	Албан шаардлага
12	8.1	Төсвөөс дүрэмт хувцас худалдан авсан	0.2	Төлбөрийн акт

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

13	15.1.5	Төсвөөс бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	1.0	Төлбөрийн акт
14	15.1.8	Байгууллагын төсвөөс спорт, урлагийн уралдаан тэмцээн зохион байгуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй /сумын Засаг даргын зөвлөлийн шийдвэргүй/	3.1	Албан шаардлага
15	15.1.8	Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спорт, урлагийн арга хэмжээ зохион байгуулж шагналын зардал гаргасан	3.3	Төлбөрийн акт
16	15.1.8	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Спортын наадам зохион байгуулсан	5.0	Албан шаардлага
17	6.2	Зөвлөлийн дарга хот дотор автомашин ашиглаж, 1,707.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулан Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн байна.	1.7	Зөвлөмж
18	15.1.8	Төсвөөс багийн өдөрлөг, урлаг, спортын тэмцээн зохион байгуулж шагнал урамшуулал, ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн төсвийг үр ашиггүй зарцуулсан.	15.1	Албан шаардлага
19	15.1.8	Засаг даргын нөөц хөрөнгөөс УБ хотод зохион байгуулагдсан "Завхан 2025" спортын их наадамд баг тамирчдыг бэлтгэж оруулахад зориулж 2,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж, мөн Үндэсний бахархлын өдөрт зориулж сумын хэмжээнд спортын 3-н төрлөөр тэмцээн зохион байгуулахад зориулж медалийн үнэ 504.0 мянган төгрөгийг төлсөн	2.5	Албан шаардлага
20	15.1.2	Тамгын газрын бүтэц орон тоог анх батлахдаа 1 орон тоо илүү, шинэчлэн батлахдаа албан тушаалын давуу байдал үүсгэж шинээр Хууль, эрх зүй, дотоод асуудал хариуцсан мэргэжилтний орон тоо нэмж нийт 2 орон тоо илүү ажилсан	1.7	Албан шаардлага
21	15.1.8	Засаг даргын нөөц хөрөнгөөс сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээний спортын хувцасны үнэ 2.4 төгрөгийг төлсөн, өсвөрийн Жудо бөхийн аймгийн аварга шалгаруулах уралдаан тэмцээн зохион байгуулж, шагналд 6.0 сая төгрөгийг зарцуулсан	8.4	Албан шаардлага
22	15.1.8	Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,222,8 мянган төгрөгийг сургуулиас зохион байгуулсан тэмцээн уралдаанд дэмжлэг олгосон зөрчил байна.	1.2	Зөвлөмж
23	15.1.8	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Биеийн тамир уралдаан тэмцээний зардлыг төсвөөс зарцуулсан	6.0	Албан шаардлага
24	15.1.8	Төрийн албан хаагчдын зөвлөгөөн зохион байгуулж тэмцээн уралдаан, сургалт зохион байгуулсан	5.0	Албан шаардлага
25	15.1.8	Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан, хуульд зааснаас өөр хэлбэрээр шагнал урамшуулал, дэмжлэг олгосон	2.7	Төлбөрийн акт
26	10.2	Ёс зүйн дэд хорооны гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгосон	3.0	Төлбөрийн акт
27	12.1.3	Хэвлэлийн зардал гаргаж төсвийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан	0.4	Төлбөрийн акт
28	12.1.1	Байгууллагын төсвөөс албан хаагчдын утасны төлбөрийг төлсөн	1.7	Төлбөрийн акт
29	15.1.8	Төсвөөс спорт, урлагийн арга хэмжээнд 9,000,000 төгрөгийг зарцуулж, зориулалт бус зардал гаргаса	9.0	Албан шаардлага
30	15.1.5	Ажилчдад 1210 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл өгсөн	1.2	Зөвлөмж
31	15.1.5	Аймгийн Засаг даргын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх гэх үндэслэлээр төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах орон сууцны дэмжлэг, уралдаан тэмцээний шагнал, урамшуулал, хоол хүнсний материал, бэлэг дурсгалд 1,285.0 сая төгрөг зарцуулсан.	1,285.0	Албан шаардлага
<b>Дүн</b>			<b>1,473.1</b>	

Дээрх зөрчлийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтаар харуулбал:

- ✓ 6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчин зөвлөлийн дарга хот дотор автомашин ашиглаж 1.7 сая төгрөгийн шатахуун зарцуулсан;
- ✓ 8 дугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчин хуульд зааснаас бусад албан хаагчид 0.2 сая төгрөгийн дүрэмт хувцас худалдаж авсан;

## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

- ✓ 10 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчин ёс зүйн хорооны гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур 5.2 сая төгрөгийн урамшуулал олгосон;
- ✓ 11 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг зөрчин тэтгэвэрт гарсан албан хаагчид 1.1 сая төгрөгийн тэтгэмжийг давхардуулж олгосон;
- ✓ 12 дугаар зүйлийн 1.1 дахь заалтыг зөрчин байгууллагын төсвөөс албан хаагчдын утасны төлбөрт 1.7 сая төгрөгийг зарцуулсан;
- ✓ 12 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг зөрчин хэвлэлийн захиалгын төлбөрт 0.4 сая төгрөгийг зарцуулсан;
- ✓ 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.8 дахь заалтуудыг зөрчин тэтгэмж, дэмжлэг олгосон, телевизийн нэвтрүүлэг, контент, сурталчилгаа хийсэн, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчилд 1,462.8 сая зөрчил гаргасан;

Тайлант оны зөрчлийг өмнөх онтой харьцуулахад зөвлөмж 19.3 сая төгрөгөөр буурч, албан шаардлага 691.7 сая төгрөгөөр, төлбөрийн акт 20.7 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 20. ТХТХ-ийн зөрчил

/сая.төгрөгөөр/

Он	Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт тоо	Нийт мөнгөн дүн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн		
2024	3	1.7	16	754.9	2	15.2	21	771.8
2025	12	22.4	16	1,446.6	3	4.1	31	1,473.1
<b>Зөрүү</b>	<b>9</b>	<b>20.7</b>		<b>691.7</b>	<b>1</b>	<b>-19.3</b>	<b>10</b>	<b>701.3</b>

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хэмнэлтийн горимд шилжүүлсэн зардлуудын гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

**Цалин, НДШ-ийн зардал:** Цалин, НДШ-ийн зардлыг 28,600.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 27,412.7 сая төгрөгийг зарцуулж, 1,187.4 сая төгрөгөөр буюу 22.7 хувиар хэмнэсэн байна.

**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:** Төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлыг 19,153.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 17,590.2 сая төгрөг зарцуулж, 1,563.1 төгрөг буюу 29.9 хувиар хэмнэсэн байна. Тогтмол зардлыг 1,563.1 сая төгрөгөөр хэмнэсэн боловч улсын төсөвт байгууллагууд 282.1 сая төгрөгийн халаалтын зардлын өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

**Бичиг хэргийн зардал:** Бичиг хэргийн зардлыг анх 183.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 144.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 39.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

**Тээвэр, шатахууны зардал:** Тайлант онд тээвэр, шатахууны зардлыг 732.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 620.4 сая төгрөг зарцуулж, зардлыг 112.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

**Томилолтын зардал:** Томилолтын зардлыг тайланд онд 459.9 сая төгрөгөөр баталснаас 422.2 сая төгрөгийг зарцуулж, 37.9 сая төгрөгийг хэмнэжээ.

**Урсгал шилжүүлэг:** Бусад урсгал шилжүүлгийг 1,117.4 сая төгрөгөөр төлөвлөж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 159.5 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 178.2 сая төгрөг, тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 298.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 64.9 сая төгрөг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 130.6 сая төгрөг зарцуулж, 713.8 сая төгрөг хэмнэжээ. Дээрх зардлуудыг хэмнэсэн шалтгаан нь Сангийн яамнаас зарцуулах эрхийг хязгаарласантай холбоотой байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг 5 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж, орон нутгийн төсөвт 107.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажилласан байна. Үүнд:

**Нэг. Хөрөнгийн бүртгэлийн талаар:** Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг бүртгэх ажлыг ОНӨГ нь тухай бүр зохион байгуулж дараах хөрөнгийг бүртгэлд тусгуулан ажилласан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2,524.4 сая төгрөгийн, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 19,760.1 сая төгрөгийн, шилжүүлэн авсан 1,801.1 сая төгрөгийн, дахин үнэлсэн 577.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

**Хоёр. Хөрөнгийн ашиглалт зохицуулалтын талаар:**


**Дуудлага худалдаа:** 2025 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2025 оны А/23, А/72, А/96 дугаар бүхий 3 захирамжаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 883.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий 38 тээврийн хэрэгслийн дуудлага худалдааг нийт 5 удаа зохион байгуулж 21 тээврийн хэрэгслийг худалдаж орон нутгийн төсөвт нийт 107.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Түрээсийн гэрээ: 2025 онд Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 21 түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж 17.5 сая төгрөгийн түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх ажлын хүрээнд:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2025 оны А/22, А/94 дугаар бүхий 2 захирамжаар 506.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий 5 тээврийн хэрэгслийг аймгийн ХХҮГ, аймгийн ЗДТГ, Алдархаан сумын ЗДТГ, аймгийн Байгаль орчны газар, Шилүүстэй ЭМТ-д шилжүүлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**  
 ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 1,473.1 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

**4.2 Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 онд орон тоог 10.6 хувиар бууруулан тодотгосон боловч гүйцэтгэлээр 9.8 хувиар буурсан байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 58 байгууллагын орон тооны дээд хязгаарыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 841 байхаар баталж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолоор 89 орон тоо буюу 10.6 хувиар бууруулж, 752 орон тоогоор тодотгон баталсан байна. Гүйцэтгэлээр 759 орон тоотой ажиллаж, харьяа байгууллагууд 9.8 хувиар бууруулсан байна.



**4.3 Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 3,990.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Завхан аймгийн Засаг даргын 2025 оны шилэн дансны цахим системд байршуулсан мэдээллийг шалгахад мэдээлбэл зохих 157 мэдээллээс хугацаанд нь мэдээллэсэн 128, хугацаа хоцроож мэдээлсэн 20, мэдээллийг оруулаагүй 6, хуулийн хугацаа болоогүй 3 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

**Хүснэгт 21. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны мэдээлэл	Нийт мэдээлбэл зохих	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Мэдээлээгүй	Хугацаа болоогүй
Төсөв гүйцэтгэл	81	59	16	3	3
Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	27	22	3	2	
Бусад	49	47	1	1	
<b>Нийт</b>	<b>157</b>	<b>128</b>	<b>20</b>	<b>6</b>	<b>3</b>

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэхэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 12 байгууллагад 3,990.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй болон харьяа байгууллагуудын Шилэн дансны цахим системд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

**БҮЛЭГ 5. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

**5.1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.**

Аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 3,766.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4 заалт зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг үнэлэхэд 3,766.0 сая төгрөгийн албан шаардлага болон 2 заалт зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 2 заалт зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, биелэлт 60 хувьтай байна. Өмнөх аудитаар өгсөн 2 заалт зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Хүснэгт 22. Өмнөх оны шийдвэрийн хэрэгжилт**

№	Илэрсэн зөрчил	Мөнгөн дүн	Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн утга	Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт
<b>Аймгийн Засаг даргад</b>				
1	Төсвийг үр ашиггүй, үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан зөрчил буурахгүй давтагдан гарч байна. Шат, шатны Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн давсан орлогоос нэмэгдүүлэн баталж байгаа нь төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.	-	Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, өр авлага үүсгэхгүй ажиллах;	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд зориулалт бус зарцуулалттай 2,385.7 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
2	ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7 дахь заалтуудыг зөрчин тэтгэмж, дэмжлэг олгосон, телевизийн нэвтрүүлэг, контент, сурталчилгаа хийсэн, бэлэг дурсгалын зүйл худалдан авч 753.3 сая зөрчил гаргасан байна.	-	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар шат, шатны төсөв захирагч нарт үүрэг өгч, биелэлтийг тооцон ажиллах;	ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 1,473.1 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт зөрчлийн 43.7 хувь нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.	-	Төсвийн төлөвлөлт, хөтөлбөр арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүйгээр төсвийг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах;	2025 онд урсгал зардлыг 10.1 хувиар нэмэгдүүлсэн ч 39.4 хувиар хэмнэсэн байна. Иймд зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан гэж дүгнэлээ.
4	ТЕЗ-н нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харьяа байгууллагуудын хэрэгжүүлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээ гэрээний хугацаанд хийгдээгүй, бүрэн дуусаагүй 3,766.0 сая төгрөгийн зөрчил илэрч, аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй зөрчил давтагдан гарч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна	3,766.0	Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй төсөл арга хэмжээний төсвийг зохистой, үр ашигтай удирдаж, гүйцэтгэлийг бүрэн ханган ажиллах	Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.
<b>Аймгийн Татварын газарт</b>				
5	Орон нутгийн татварын орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн боловч 7 нэр төрлийн орлого тасарсан байна.	-	Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах;	Аймагт төвлөрөх татварын болон татварын бус орлого 46.2 хувиар давж биелсэн байна. Иймд зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэж дүгнэлээ.

### **АУДИТЫН ДҮГНЭЛТ**

1. Аймгийн төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлого 46.2 хувиар давж биелсэн ч 16 суманд орлого тасарч, татварын орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлээгүй байна.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд төсвийг үр ашиггүй, хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан 2,385.7 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Шат, шатны төсөв захирагчид батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, Төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,473.1 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Шат, шатны төсөв захирагчид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
4. Хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөлтийг бодитой, үндэслэл, тооцоололтой хийгээгүйгээс төлөвлөсөн хэмжээнд зээл олгох боломжгүй нөхцөл үүсэж, гүйцэтгэл 58.2 хувьтай байгаа нь нэгдсэн төсвийн гүйцэтгэл буурахад сөргөөр нөлөөлсөн байна. Иймд Хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөлтийг бодит тооцоололд үндэслэн хийж, гүйцэтгэлийн бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд шилэн дансны цахим системд оруулах 157 мэдээллээс 20 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг огт мэдээлээгүй, Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, харьяа байгууллагуудын шилэн дансны цахим системд тавих хяналтыг хэрэгжүүлээгүйгээс санхүүгийн тайлангийн аудитаар 3,990.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

**ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Г.ӨНӨРБАЯРТ:**

1. Шилэн дансны цахим системд төсөв, санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн оруулж, харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж, зөрчлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах;

**СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ**

1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр бүрэн биелүүлж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах;
2. Хоршоо хөгжүүлэх сангийн орлого зарлагыг бодитой, үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хатанбаатар Магсаржавын 1-116 тоот  
Улиастай сум, Завхан аймаг 81090  
Утас: 7575-1155, Факс: 7046-2550  
Цахим шуудан: info@zavkhan.gov.mn  
Цахим хуудас: Zavkhan.gov.mn

2026-04-24 № 08/433  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ Т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЧАДРААБАЛ



01/2026/Албан тоот 5  
8126170438